



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 05 өдөр

Дугаар А/123

Чингис хот

□ Бүх нийтийн эрх зүйн боловсролын хүрээнд □
сургалт зохион байгуулахад хөрөнгө
зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.1-ийн "а", Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.1, 58.2.20, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хоёрдугаар хуралдааны 2020 оны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.3.2-т заасан Бүх нийтийн эрх зүйн боловсролын хүрээнд иргэд, аж ахуй нэгж байгууллагуудад холбогдох хууль тогтоомжийг сурталчлах, хүний эрх, хууль, эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх сургалтыг төрийн бус байгууллагатай хамтарч зохион байгуулах зардалд зориулж 10 000 000/ арван сая/ төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулах төсвийн тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж. Ганбаатар/-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010332

Аймгийн Засаг даргын 2021 оны
 ...08... дугаар сарын...05...өдрийн ...А/М/С...
 дугаар захирамжийн хавсралт



**"БҮХ НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР"-ИЙН
 ХҮРЭЭНД БҮХ НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН БОЛОВСРОЛ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
 СУРГАЛТЫН ТӨСВИЙН ТООЦОО**

№	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хүрэх түвшин, үр дүн	Санхүүжүүлэх эх үүсвэр /сая төгрөг/	Хариуцах байгууллага
1	Сумдад Хууль зүйн зөвлөгөө, мэдээллийн цахим сан "e-khutuch.mn" булан мэдээлэл оруулах	2021 оны 1 дүгээр улиралд	Бүх сумд, тосгонд, "e-khutuch.mn" сайтад мэдээлтэй болсон байна.	-	СЗДТГ
2	Хууль тогтоомжийг сурталчлах, сургалтыг иргэд болон төрийн албан хаагчдад цахим болон танхимаар зохион байгуулах	Улирал бүр	Иргэдийн эрх зүйн мэдлэг дээшилсэн байна.	5.000.000	ХЭЗХ
	Төрийн албан хаагчдад зориулсан сургалт				
	Иргэдэд зориулсан сургалт				
	Эрх зүйн хөтчөөр бэлтгэсэн хөтөч ажилтнуудад давтан сургалт зохион байгуулах		Хөтөч нар иргэдэд сургалт зохион байгуулах эрх зүйн мэдлэг дээшилсэн байна.		
3	Эрх зүйн сургалт, сурталчилгааны гарын авлага, боршур, шторк хийх, сумдад хүргүүлэх	2021 оны 1 дүгээр улиралд	Иргэдийн хууль, эрх зүйн боловсрол мэдлэг дээшилсэн байна.	1.800.000	ХЭЗХ
4	Эрх зүйн хөтчөөр бэлтгэсэн хөтөч ажилтнуудад цахим сургалт зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх	2021 оны 1 дүгээр улиралд		1.200.000	ХЭЗХ
5	Цахим сургалт зохион байгуулахад шаардагдах чихэвч, камер авах санхүүг шийдвэрлэх	2021 оны 1 дүгээр улиралд		2.000.000	ХЭЗХ
				10 000 000	